



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/230

Бат-Өлзий сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Түвшин (Газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Ж.Алтангэрэл (Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн нярав)

Ш.Бумандолгор (Ойн инженер)

Б.Сангицэрэн (1 дүгээр цэцэрлэгийн нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: Б.Пүрэвсүрэн (Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч)

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Нямхүү)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Н.Түвшин)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ



D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

- 622301389